

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

№ 24/34

Улаанбаатар хот

**Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх
эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.23 дахь заалтууд болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тус эрэлтийг хангах, өөрийн бүтээгдэхүүнийг зах зээлд үе шаттайгаар нэвтрүүлэхэд эх үүсвэрийн хэрэгцээ байгааг харгалзан “Хаан банк” ХК-аас энэхүү тогтоолын Хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд нийт 4,000,000,000 (Дөрвөн тэрбум) төгрөгийн зээл авахаар шийдвэрлэсүгэй.
2. “Хаан банк” ХК-тай энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж битлэн шилжүүлэх, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. “Хаан банк” ХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

№ 24/35

Улаанбаатар хот

**Компанийн шинэ оффисын
тохижилтын төсөв батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол /14252/ Сөүлийн гудамж 13А хаягт байрлалтай оффис үйлчилгээний зориулалттай “Алтан Жолоо Тауэр”-ын 10 дугаар давхрын 01 тоот 715.21 м.кв талбайг түрээсэлж байгаатай холбогдуулан шинэ оффисын тохижилтын төсвийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан төсөвт багтаан Компанийн шинэ оффисын тохижилтын ажлыг гүйцэтгэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

№ 24/36

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 434 тоот тогтоолоор батлагдсан “Итгэлцлийн үйлчилгээний журам”-д нийцүүлэн Компанийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үзүүлж буй “Итгэлцлийн үйлчилгээ”-ний похцол, шаардлагыг тодорхой болгох, итгэмжлэгч харилцагчийн эрх ашгийг хамгаалах, талуудын хоорондын харилцааг зохицуулах зорилтын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан журамтай холоогдуулан Компаниин үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР